



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН  
ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Г Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар  
хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга Б.Хоролсүрэн тэтгэвэрт гарсан, гишүүн С.Нэргүйбор, нарийн бичгийн дарга Б.Одонтuya нар үндсэн ажлаасаа 2 жилийн чөлөөтэй байгаа тул сонгон шалгаруулалт, санал асуулгын дагуу орлогч дарга Н.Долгорсүрэнг ёс зүйн салбар хорооны даргаар, хүний нөөцийн менежер Б.Одончимгийг нарийн бичгийн даргаар, тус төвийн хуулийн зөвлөх Д.Анхбаяр, их эмч Н.Өлзийтогтох нарыг гишүүнээр тус тус 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Шинээр томилогдсон гишүүдэд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 256 дугаар тушаалаар батлагдсан “Дүрэм батлах тухай” тушаалыг танилцуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг ёс зүйн салбар хорооны дарга Н.Долгорсүрэнд даалгасугай.

ДАРГА

Д.ОЮУНБИЛЭГ

